

“С. БУЯННЭМЭХ СУДЛААЧ” НЭРТ ЭРДЭМТЭН ВАН МАНДУГА

До.Цэнджав*

Монголын уран зохиолын гучаад оны үе бол нэг намын үзэл суртлын нөлөө харьцангуй сулавтар, хөгжлийн эхэн үе байсан тул гаднын нөлөөлөл бага байсан учраас зохиолч, шүлэгчид өөр өөрсдийн бодол, төрөгдөл, төсөөлөлөөрөө албадмал бус аргаар бичиж байсан болохоор “чөлөөт сэтгэлгээний үе” ч гэж болохоор санагддаг. Иймээс арга барилын хувьд судлаачдын сонирхлыг татаж ирснээр өнөөгийн бидний ярьдагчилан олон урсгалт уран зохиолын үр хөврөл бүрэлдэж байжээ. Энэ нь европын туурвилзүйн мөн чанар, утга зохиолын шинэ онолыг тэгтлээ сүрхий тусгаж тэр чиглэлээр хөгжүүлж байсантай холбоотой бус, ерөөс зохиолч өөрсдийнх нь оюун сэтгэлгээ, жам ёсны үйлдэл байсантай холбоотой. Манай орчин үеийн уран зохиолын онол, шүүмжлэл, түүхийн хуудсанд гучаад оны уран зохиол гайхам бишрэм шинэ үеийг тунхагласан гэхэд хэцүү ч, бүтээвэр, зохиомж, өгүүлэгдэхүүн, агуулга, арга барилын хувьд яахын аргагүй анхаарал татам сонирхолтой үе гэхэд болно. Манай ахмад болон дунд үеийн судлаач шүүмжлэгчид чамгүй зүйлийг бичсэн ч гэлээ, гагц энэхүү сэдвийг судалгааны гол зорилго болгон тууштай барьж гүнзгий орж, тал бүрээс тайлан тайбарласан, ховор олдврыг нийтэд дэлгэсэн, шинээр нээсэн зүйл элбэг биш юм. Утга зохиолын судлаач эрдэмтэн Д.Цэнд “Орчин үеийн уран зохиолын судлал, шүүмжлэлийн тойм” бүтээлдээ 1929-1964 оны хоорондох утга зохиолын хөгжил, шүүмжийн тухай анх удаа хөндөн гаргасан нь бусдын анхаарлыг энэ зүгт хандуулахад чухал алхам болжээ. Үүний дараа судлаач шүүмжлэгч Ц.Мөнх “Монголын шинэ үеийн уран зохиолын шүүмжлэлийн түүхэн найруулал” ном бичиж, шүүмжлэлийн тоймыг гарган тавьж, үзэл сурталжсан, хатуу хяналттай социаслит реализмын аргыг голчилж байсан үед ихээхэн зөв баримжаалалтай дүгнэлт өгсөн нь үнэндээ хаалттай хаалганд ямар ч байсан завсар зай гаргажээ.

Үнэндээ намын үзэл сурталчид 30-аад оны уран зохиолын төлөв байдал, гол гол төлөөлөгчдийн бүтээлээс цэрвэж, тэр тухайд ярихаас зайлсхийж байсан нь түүхийн цагаан толбо хэлмэгдүүллийн хор уршигтай холбоотой. Энэ үед ид хийж бүтээж явсан гол гол зохиолч улстөрийн хэлмэгдэлд өртөж, зохиол бүтээл нь хураагдаж, ихэнхдээ үрэгдэхэд хүрсэн. Тавиад онд улс төрийн талаар хэлмэгдсэн зохиолчдыг бие хувь хүний хувьд цагаатгасан боловч, хэлмэгдсэн уран бүтээлийг нь цагаатгалгүй орхисон юм. Иймээс энэ үеийн бүтээл туурвил удтал утга зохиол судлалд “хаалттай бүс” хэвээрээ байв. Энэхүү хаалттай бүсийг сэтлэн давах анхны үйлсийг судлаач Г.Дүйнхэржав дотоод яамны архивт ажиллаж байсны хувьд ихээхэн эр зориг гарган С.Буяннэмэх, М.Ядамсүрэн, Ш.Аюуш нарын зохиолыг бүртгэж, цуглуулж, эмхэтгэн хэвлэх, оршил намтар тайлбарыг бичсэнээр энэхүү “сэжиг” бүхий үеийн судалгааг эхлүүлсэн гавьяатай. Тэр үеийн зохиолчдын байгууллагын удирдагч С. Удвал болоод ялангуяа МЗЭ-ийн шүүмж судлалын зөвлөлийн эрхлэгч Ц.Мөнх чамгүй анхаарал тавьжээ. Д.Цэнд, Ц.Мөнх хоёроос өөр эрдэмтэд энэхүү ээдрээ зөрчилтэй гучаад оны үеийн уран зохиол судлал руу зөвхөн “далайн захад хөл дүрэх” хэмжээнд л хааяа үг дуугарч байсан нь , нэгд

*Монгол Улсын Их Сургууль

улстөрийн учир шалтгаантай, хоёрт, маш их хэмжээний олдоцгүй материалыг цуглуулж эрж хайх учиртай, гуравт, монгол бичгийг төгс чадварлаг эзэмшсэн байх шаардлагатай байв. Дээхнэ үеийн сэхээтнүүд монгол бичгийг сайтар эзэмшсэн байсан учир энэ нэг их саад байгаагүй ч, арай залуу хэсэг нь түүнээс ихэд салж төсөөрсөн байв.

ЗО-аад оны уран зохиолын гол индэр “Уран үсгийн чуулган” сэтгүүл, (1929), “Хувьсгалт уран зохиол” сэтгүүл (1932) “Шинэ толь” (1938) “Ардын үндэсний эрх”(1838) “Хувьсгалт залуучуудын эвлэл” (1928) байв. Энэ бүх саадыг давж, хуучин сэтгүүл, сонин, архивын өдий төдий нууц далд болоод нээж дэлгэж тавиагүй материал руу нэгэн биеийн зовлонг туулан орж, жинхэнэ эрдэмтэн хүний нөр их хөдөлмөр зүтгэлийг гарган тууштай орсон эрдэмтэн бол эдүгээ Бээжингийн Төвийн үндэстэний Их сургуулийн Монгол хэл соёлын сургуулийн захирал профессор Ван Мандуга юм. Монгол судлал, тэр дотроо орчин үеийн гучаад оны үеийн утга зохиолын судлалыг энэ эрхмээс ангид авч үзэх аргагүй учраас эхлээд түүний товч намтрыг мэдээлэх нь зүйн хэрэг.

Шинжлэх ухааны доктор, профессор Ван Мандуга ӨМӨЗО-ны Жирэм аймгийн Хорчин зүүн гарын хойт хошуунд 1955 ? онд төржээ. Тэрбээр бусдын адил ерөнхий боловсролын сургуулиудыг дамжиж, 1982 онд төрөлх сургууль болох Бээжингийн Төвийн үндэстний их сургуулийг төгссөн байна. 1991-1992 онд МУИС-д мэргэжил дээшлүүлжээ. Ингээд 1995 онд Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд “Монголын уран зохиолын онол шүүмжлэлийн судалгаа” сэдвээр дэд докторын зэргийг амжилттай хамгаалжээ. Дараа нь Японы Ки- фүгийн Их сургуульд 1999- 2000 он хүртэл суралцаж орчин үеийн японы хэл-уран зохиол судалж, японы хэлийг чадамгай эзэмшжээ. 2000-2003 онд Бээжингийн Төвийн Үндэстэний их сургуулийн докторонтурт суралцаж, 2003 онд шинжлэх ухааны доктор цолыг “Монголын орчин үеийн уран зохиолын онол-шүүмж-судлал” (1921-1940) сэдвээр хамгаалсан байна. Ван Мандугайн монгол судлалд оруулсан их хувь нэмрийг үнэлж МУИС-ийн Монгол хэл соёлын сургуулийн хүндэт доктор, СУИС-ийн хүндэт доктор, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн хүндэт доктор, “Улаанбаатар” Их сургуулийн хүндэт доктор, Баруун хойтын Үндэсний Их сургуулийн зочин профессор зэрэг цолыг тус тус хүртжээ. Энэ нь түүний ямар хэмжээний судлаач болох зиндааг тодорхойлж байна. Одоо эрдэмтэн Ван Мандуга 2002 оноос хойш Олон улсын монгол судлалын холбооны гишүүн, БНХАУ-ын Монгол судлалын нийгэмлэгийн байнгын хэрэг эрхлэгч, дэд нарийн бичгийн дарга, БНХАУ-ын Монголын утга зохиолын нийгэмлэгийн Хэрэг эрхлэгчдийн дэд эрхлэгчийн сонгуультай ажиллаж байна. Улаанбаатар хотод болсон Монголч эрдэмтдийн их хуралд 1992 оноос оролцсоноос гадна ҮШ, IX, X их хуралд илтгэл тавьж оролцжээ.

Ван Мандуга утга зохиолын судалгааны ажлыг бүр оюутан цагийн гуравдугаар ангиасаа эхэлж, сургууль, эрдэмтэн багш нарынхаа анхаарлыг татаж чаджээ. Анхны судалгаа нь Инжиннашийн “Хөх судар” болон “Монголын нууц товчооны” Чингис хааны дүрийг харьцуулан судалсан нь ихээхэн сонирхолтой судалгаа төдийгүй энэ залуугийн ирээдүйн эрдмийн зам мөрийг хөөх эхлэлийг тавьжээ. Монголын шинэ үеийн уран зохиолын үндэслэгчийн нэг, ууган зохиолч С.Буяннэмэхийн судлал руу 1989 оноос орж, үүгээр дамжин хэлмэгдсэн зохиолч М.Ядамсүрэн, Ши.Аюуш, Ч.Дашням, Д.Чимэд, Ц.Дамдинсүрэн, Б.Содном нарын амьдрал уран бүтээлийн онцлогийг судалж ном бүтээлээ гаргасан байна. Судалгаагаа алхам алхмаар лавшруулсаар Б.Ринчен, Д.Цэвэгмидийн бүтээл туурвилыг ч судалжээ. “Монголын уран зохиолын түүхэн цаг үеийн ЗО-аад оны судалгаа иж бүрдмэл биш, тойм бүрхэг, гүйцэд лав ороогүй, хамрах хүрээ хязгаарагдмал, зарим нь мэдээлэл төдий, тайлж тайлбарласан дүгнэлт янз бүр, заримдаа эргэлзээтэй ончтой бус, утга зохиолын бусад үеийнхээс судалгаа хоцронгуй байсан байдлыг нэхэн хөөх, нөхөн нээх, харьцуулалт аналогийн аргаар судалж, өнгөрсөн цаг хугацааг хэт эдүгээчлэх туйлширлыг арилган “түүхэн зарчмыг” баримтлан, “Буяннэмэх

судлалыг” бодитойгоор бий болгосонд Дундад Улсын Өвөр монголын нэрт эрдэмтэн, монгол судлаач Ван Мандугайн судалгааны ажлын гавьяа зүтгэл оршино”

“Буяннэмэх судлалыг” гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд амьдралынхаа 20 гаруй жилийг зориулж, эдүгээ ч зориулсаар байна. Эрдэмтэн Ван Мандуга утга зохиолын судалгааны ажлыг хийхдээ, тухайн хүнтэй холбогдол бүхий олон газар орноор явж, цөхрөлтгүй эрэл хайгуул хийж, номын сан, улсын архивын газар, хувь хүний архиваас маш ховор баримт олж авах, мэдэж таних хүмүүс эрдэмтэн мэргэдтэй нүүр тулж уулзан мэдээ занги цуглуулж, олсон материалаа няхуур нямбай тал талыг бодон боловсруулж, бусад судлалд байгаа болон байхгүй зүйлтэй харьцуулж дүгнэлтээ гаргадаг судалгааны өөрийн арга барилтай нь ажиглагдлаа. Нэвтрэхэд маш төвөгтэй, бараг хаагдмал шахуу Тагнуулын төв газрын архивт хүртэл орж, зорьсон материалаа олж амжсан байна. Ингэж эрдэмтэн хүний зүтгэл бүтээлийг гаргаснаар гучаад оны утга зохиол судлалыг тогтолцоонд оруулжээ. С. Буяннэмэх Данзантаны хэрэгт нэр холбогдож, арга буюу амиа авч гарахын тулд сэхээ самбаа гарган улсын дорнод хилээр гарч Барга, Өвөрмонголд гараад юу чухам хийж бүтээж байсан, ямар нөхөдтэй холбоотой ажиллаж байв зэрэг намтрын балархай бүдэг үеийг судлан шинэ мэдээллийг гаргаж, түүний намтар судлалд хувь нэмрээ оруулсан юм.

Өөрөө утга зохиолын онол, шүүмж судлалаар дагнадагийн хувиар С.Буяннэмэхийн онол, шүүмжлэлийг илүүтэй сонирхож, онолын дүгнэлт гаргажээ. Түүний “Утга зохиолын үүд”, 1936 оны “Шинэ толь” сэтгүүлийн № 3.4 –д нийтлэгдсэн “Шинэ үеийн уран зохиол” зэрэгт нийтлэгдсэн утга зохиолын онол, зарчмын зүйлийг гарган дэвшүүлж, өөрийн дүгнэлтийг гаргасан нь Монголын уран сайхны шүүмж судлалд жинтэй хувь нэмрийг оруулсан гэж болно. Зохиолчийн амьдралыг судлахдаа заавал хэн нэгнээс үүвэр түүвэр сонссоноо бичих биш, нүдээр үзэж, чихээр сонсож, ихээхэн эрэл сурал тавьдагийг үүнийг бичиглэгч биеэрээ үзэж мэдэрсэн юм. 2012 оны хур бороо жигдэрсэн зуны дэлгэр цагаар профессор Ж.Баянсан бидний нөхөд С.Буяннэмэхийн турсэн нутаг Дундговь аймаг, аймгийн төвөөс цааш Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Мандалговиар мянга гаруй км замыг туулж, С.Буяннэмэхийн хамаатан садан төрлийн бүх хүмүүстэй уулзаж нягт нямбай тэмдэглэл хөтөлсөн юм. “Зохиолчийн намтар судлал” гэдэг бол зохиолчийн ертөнцийг үзэх үзлийг тодруулаад зогсохгүй заримдаа зохиол туурвилын хувь заяа, далд үл ойлгогдох зүйл, эргэлзээтэй зүйлийг тайлахад нэн нөлөө тустай байдаг. Иймээс л “Зохиол бол зохиолчийн араншин байдаг” гэсэн хэлц үг гарсан болов уу?

Манай утга зохиолын шүүмжлэл “далд утгат” шүлэг гэгчийг 70 жилийн турш элдвээр шүүмжилж ирсэнийг “Буяннэмэхээс далд утгатай шүлгийг чухалчилж тайлбарлахыг эрсэн шүлэг бичиж оролдож байсныг мөн дэндүү дутагдалтай шал дэмий оролдлого гэх мэтээр үзэж болохгүй, харин зохиолчийн урлагийн замнал дундах эрэл хайгуул” гэж үзэх ёстой гэж анх дуугарсан хүн Ван Мандуга юм. “Эрэл хайгуул” гэж үзэх ёстой гэдэг үг аргагүй л голыг олж хатгасан дүгнэлт байв. Эрдэмтэн хүний үнэлгээнээс нэг үг ч болохноо эрдэнэ мэт чухаг байдаг.

Ван Мандугагийн судалгаа шинжилгээний ажлын нэг зарчим бол дангаараа биш, бусад эрдэмтэдтэй хамтарч, хүчээ хавсаргавал, илүү үр бүтээл гаргана гэсэн үзлийг баримталдаг нь ганц нэр төрийн асуудал биш жинхэнэ шинжлэх ухааны төлөө төрсөн эрдэмтний ухаан гэдгийг харуулж байна. Ялангуяа сүүлийн 20 гаруй жилийн туршид Монголын утга зохиол судлал руу гүнзгий орж, судалгааны чухаг үнэт зүйлсийг бий болгож байгаа эрдэмтэн бол доктор, профессор Д.Цэдэв юм. Тэрбээр их зохиолч Д. Нацагдоржийн зохиол бүтээлийн иж бүрэн гурван ботийг эх бичгийн буюу “текстлогийн” үнэн бодит судалгаанд тулгуурлан, өмнөх үзэл сурталжсан болоод буруу ташуу ойлгосон алдааг засаж чадсан юм. Ван Мандуга 2002 онд Д.Цэдэвтэй олон улсын монголч эрдэмтдийн YIII их хурлын үеэр тохиол таарч, суудал зэрэгцэн сууж сайтар танилцсан байна. Юманд ултай ханддаг нягт нямбай, уйгагүй хөдөлмөрч, аливаа туйлшралд авталгүй бодит үнэнд тулгуурладаг гээд ижил төстэй зүйл энэ хоёр эрдэмтэнд

бий. Хэдийгээр сүүлд хамтарч нийлсэн ч гэлээ Д.Цэдэвтэй хамтран ажиллах болсноор түүний судалгааны ажил улам өргөжиж, улам жинтэй болж, улам шинэ шинийг нээх бололцоо гарсан байна. Д.Цэдэв аругай Буяннэмэхтэй холбогдох материалыг Оросын Буриадаас олсон бол Ван Мандуга Өвөрмонголоос ховрыг шүүрдэн олж “Буяннэмэх судалгаанд” мэдэгдэхгүй, таамаг яриа төдий байсан олон зүйлийг тодруулж чадсан юм. С.Буяннэмэх Өвөр монголд гараад “Дотоод Монголын Ардын сэтгүүлийн” эрхлэгчээр ажиллаж, тус сэтгүүлийн 1-ээс 9 дугаарыг гаргасан гэсэн мэдээ бидэнд мэдэгдэж байсан боловч бүрэн бүрдүүлж чадахгүй байсаар өдий хүрсэн. Тэгвэл нэгэн баг болж ажилласан энэ хоёр эрдэмтний чармайлтаар тэрхүү сэтгүүлийн 8 дугаарыг бүрдүүлж чадсан нь Монголын утга зохиол судлалд маш үнэ цэнтэй зүйл болжээ. Энэхүү 8 сэтгүүлийн эх зургийг хуулбарлан буулгаж, тайлбар сэлт хийж, юу юу нийтлэгдсэн жагсаалтыг гаргаж, иж бүрнээр бүртгэж, тус сэтгүүлийн нийтлэлийн бодлогыг тодорхойлсон нь ганц утга зохиолд төдийгүй сэтгүүлзүйн судалгаанд ихээхэн хувь нэмрийг оруулжээ. Ингэсний эцэст Ван Мандуга, Д.Цэдэв хоёр хамтран юу юу хийхээ товлон хувааж аваад монгол бичгээр “Сономбалжирын Буяннэмэх” хэмээх дөрвөн ботийг нийтлүүлсэн нь хамгийн гүйцэд, хамгийн бүрэн, хамгийн тулгуур эх болгож барих цэгцтэй боть гэж бүрнээ дүгнэж болно. Үүнд урд өмнөх түүврүүдэд ороогүй олон материал оржээ. Дөрвөн ботийн тоймыг өгүүлбэл,

Нэгдүгээр ботид: Яруу найраг ший жүжиг

Хоёрдугаар ботид: Үргэлжилсэн үгийн зохиол

Гуравдугаар ботид: Түүх бичлэг, орчуулга сэлт

Дөрөвдүгээр ботид: Судлал шүүмжлэл, бусад зүйл гэсэн ангиллын дор гаргажээ. Энэ дөрвөн ботийг манай Хэл зохиолын хүрээлэнгийн мэргэжилтнүүд кирилл бичигт буулгах ажилдаа ороод бараглажээ.

Ван Мандугайн шинжилгээний ажил зөвхөн С.Буяннэмэхээр хязгаарлагдсангүй, өмнө дурдсанчилан 30-аад оны уран зохиолын гол төлөөлөгчид болох Ши.Аюуш, М.Ядамсүрэн, Ч.Дашням, Ц.Дамдинсүрэн, Д.Чимэд, Б.Содном, Но.Данзан нарын амьдрал уран бүтээлийг судалж, орчин үеийн уран зохиолын нэгэн бүхэл бүтэн үеийн судалгааг урагш түлхэж өгсөн юм. Энэхүү судалгааны ажил бол эрдэмтэн хүнээс ихээхэн хүч чармайлт гаргах, байнгын эрэлхийллээр бүтэх амаргүй хөдөлмөр. Түүнээс биш бэлэн зэлэн зүйлийг нэгтгээд орхих асуудал биш. Хориод оны сүүлч, гуч дөчөөд оны олдоц муутай сонин сэтгүүлийн шарласан хуудас бүрийг сөхөж, том номын сангуудад байгаа материалыг шүүрдэн үзэж, хүнд суртал, хайхрамжгүй хандлага, элдэв бэрхшээлийг давж бүтээсэн байна.

Эрдэмтэн хүний нэг үүрэг, нэр төрийн хэрэг бол маш ховор таамаг төдий мэдээлэлийг олж, судалгаа шинжилгээнд оруулах нь буянтай үйлс байдаг. Жишээлэл, авьяаслаг шүүмжлэгч Ч. Дашнямын 1931-1937 он хүртэл бичиж хэвлүүлсэн 30 гаруй шүүмж, шүүмжлэл, тэмдэглэл, өгүүлэл зохиолуудыг олж судалжээ. Чимэддоржийн Дашням уран зохиол, урлагийн бүх төрөл зүйлийн онцлогийн тухай өгүүлж, тэдгээрийг хэм тэгш хөгжүүлэхийг уриалж, уран зохиолын стилийн тухай буруу үзэл ойлголтыг шүүмжилж байсны хамт өөрөө уран зохиолын стиль бүрийг анхааран шүүмж бичиж, тодорхой нэгэн зохиолыг нарийвчлан шинжлэх явдлыг эрхэмлэж байсан монголын уран зохиолын шүүмж судлалын хөгжилд их хувь нэмрийг оруулсан гол төлөөлөгч” гэдгийг тодруулан тавьсан байна.

Ван Мандуга олон жил их сургуульд багшилж зуу зуун шавьтай болж, долоон докторын ажлыг удирдаж, хоёр орны хэл судлал, уран зохиолын судалгааны хамтын ажиллагааг хөгжүүлэхэд ихээхэн санаачилга зүтгэлтэй ажиллаж байгаа дээд боловсролын шилдэг удирдагч юм. Үүний зэрэгцээ утга зохиолын онолын сурах бичиг цөөнгүйг зохиож түүнийг Дундад Иргэн Улсын цөөнх үндэсний их дээд сургуулиудад үзэх сурах бичиг, гарын авлага болж, олон үеийн оюутан сурагч, магистр, докторантуудад чиг баримжаа болжээ. Тэднээс заримыг дурдвал “Монголын уран зохиолын орчин үеийн судлал шүүмжлэл” (1999) “Монголын орчин үеийн уран зохиолын

судлал шүүмжийн хураангуй” (2000) “Монголын уран зохиолын онол шүүмжлэлийн судлал” (2007 онд кирилл бичиг дээр гарсан) “Монголын уран зохиолын онол шүүмжлэлийн хөгжлийн тойм” зэрэг сурах бичиг бүтээлүүд гаргажээ. Модернизмын тухай манайх 90 –ээд оноос хойш ярьж түүгээрээ шинэчлэл хийж байгаа гэж үздэг боловч, төдий л нээлттэй бус гэгддэг Дундад улсад бүр наяд онд Фрейд, Сартр, Кафка, Ницшегийн онол яригдаж модернист аргаар бичдэг, түүнийг дууриадаг олон шүлэгч гарсан нь өөрийн эрхгүй сонирхол татна. Энэ нь Дэн-Сяо-Пенийн “Нээлттэй хаалганы” бодлоготой холбоотой хятадын өвөрмөц онцлогтой социализмын нөлөө юм. Европын гэж болох энэхүү шинэ урсгал чиглэлийг сурах бичиг бүтээлдээ оруулж, дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулсан хүний нэг нь профессор Ван Мандуга юм.

Түүний жинтэй томоохон бүтээл нь “Монгол хятад хоёр хэл хавсарсан Дандины зохист аялгууны толь” (2000) юм. Манай тооллын долдугаар зуунд зохиогдсон энэтхэгийн яруу найргийн онолч Дандины яруу найргийн онол буюу найруулга зүйн их бүтээл “Дандины зохист аялгууг” манай эрдэмтэн мэргэд аль ХҮШ зуунаас орчуулж зохиол туурвилын онол сэтгэлгээнд гол болгож, олон бүтээлийг энэ жишгээр гаргаж байсан юм. Үүнийг манайд түгээн дэлгэрүүлсэн их номч эрдэмтэд гүүш нар бол сүмбэ хамба Ишбалжир, цахар гэвш Лувсанчүлтэм, Агваандандар буюу Дандарлхаарамба, Агваантүвдэн, халхын эрдэнэ бандид Жамьянгаравын зэрэг эрдэмт лам хуврагууд юм. Харин Дундад улсад бүр саяхан 1981 онд хэсэгчилэн орчуулж, долоон жилийн дараа бүрэн хэмжээнд орчуулсан нь манай утга зохиолд хятадын уран зохиолын нөлөө багагүй байдаг ч, Дандины зохист аялгууны онолын хувьд нангиадын нөлөө ширхэг ч байгаагүй, цэвэр энэтхэгээс төвд рүү, төвдөөс монгол руу урсан орж ирсэн “оюуны их урсгалыг” батлан харуулж байна.

Эрдэмтэн Ван Мандуга энэ их чимхлүүр хэцүү хөдөлмөрийг сургуулийг удирдах болоод олон сонгуульт нөр их ажлын хажуугаар цаг завьг гойд ашиглан бүтээжээ. “Монгол хятад хоёр хэлний хавсаргасан Дандины “Зохист аялгууны толь” номыг Б.Ринчен оршил бичиж, Х.Галдан удиртгал бичж хэвлүүлсэн “Дандины зохист аялгууны толь” (1972), Ш.Бира Х.Гаадан, О.Сүхбаатар тайлбар хийж шинэчилсэн орчуулга хийсэн “Дандины зохист аялгууны толь” (1982) Жоу-Каны бүрэн орчуулга хийсэн хятад хэвлэлийн “Зохист аялгууны толь” (1989) зэрэг дөрвөн бүтээлээр эх болгоод монгол-хятад хоёр хэлээр дүйцүүлэн харьцуулан харуулжээ. Аливаа харьцуулалтаас үнэн ба худал, зөв ба гоомой эндэгдэл илэрхий харагддаг. Галигласан орчуулга Ш.Бира нарын шинэчилсэн орчуулга хийгээд Хятадын Жоу-Каны хятад орчуулга зэрэг гурван хэвлэлийг эх барьж, бадаг дараалан дүйлгэн найруулжээ. Бадаг бүрийн утгыг монгол хуучин орчуулга, шинэ орчуулга хийгээд хятад орчуулгатай нь харьцуулж зөвөөр ойлгоход дөхөм болгож бүх зүйлийн ард зүүлт тайлбар гаргасан байна. Хоорондоо зөрчилдөж ташаарсан зүйлийг зөв чиглэл рүү оруулсан нь шинжилгээ судалгааны ихээхэн туршлага мэдлэг зарсан хэрэг болоод зогсохгүй Дандины “Зохист аялгууны толийн” орчуулгыг монгол хятад хэлэнд харьцуулсан анхны судалгаа болж, хуучин монгол орчуулгын эндүүг ариутгаснаараа бас нэг шинэ зам гарцыг нээж өгч байгаа юм. Эрдэмтэн мэргэд “Монгол хятад хоёр хэлний хавсарсан Дандины “Зохист аялгууны толь” хэмээх нэн сонирхолтой, шинжилгээ судалгаанд нэн ашиг тустай энэхүү ном бүтээлийг судалж үгээ хэлэх бизээ. Учир нь энэхүү толийг судлагчид, сонирхогч эрдэмт хүмүүн монгол угсаатанд нэн олон тул тэдэнд хожмын үгээ үлдээвэй.

Бээжин хот. 2012 оны есдүгээр сарын 21, 22-ны өдрийн баасан, бямба гараг, аравдугаар сарын 1-ний ням гараг

Wan Manduga, a professor of Beijing National University, has been contributed his efforts for the “S. Buyannemekh study” for 20 years. This note highlighted his contribution to “Mongolia study” and researched his research methodology, findings, value, and the relevance of his study.